Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 202[illegible] оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт

# ДОРНОД АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ЧАНАР, ТӨЛБӨРИЙН ХЯНАЛТЫН МЭРГЭЖИЛТЭН ШИРЗАГД ОВОГТОЙ [illegible]ИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана.** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1** Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ | Дүн шинжилгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | - | Цахим өгөгдөлд хийсэн дүн шинжилгээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. | Тусламж үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллаж байна. | 2024.01.02-2024.11.20 | 80 |
| 2 | **Арга хэмжээ 1.2** Эрүүл мэндийн даатгалын 2022, 2023 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийн эмхэтгэлийг гэрээт эрүүл мэндийн байгууллага болон олон нийтэд түгээн сурталчилна. | Мэдээллээр хангасан ЭМБ, иргэдийн тоо | - | Статистик мэдээллийг олон нийтэд түгээн сурталчилах арга хэмжээг зохион байгуулсан байна | Тус жилд зохион байгуулж буй ажил үйлс, гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын мэдээлэл, эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээгүй үзүүлэх тусламж үйлчилгээгээр болон ЭМБ-д олгосон [illegible] зэрэг бусад холбогдох мэдээллийг хэлтсийн [illegible] хаяг, фэйсбүк хуудаар дамжуулан хүргэхээс гадна [illegible] мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд хүргэж ажиллаж байна. | 2024.01.02-2024.11.20 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | **Арга хэмжээ 1.3** “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. | ... баталсан тогтоолыг хүргүүлсэн ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ-ын тоо | ... ийн 2023 оны 08 дугаар тогтоолыг мөрдөж байна. | ... хэрэгжүүлсэн байна. | “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоолыг гэрээ бүхий 18 эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан, хяналт тавин ажиллаж байна. | 2024.01.02-2024.11.20 | 100 |
| 4 | **Арга хэмжээ 1.4** ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. | Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ-ын тоо | ЭМДҮЗ 2023 оны 06 дугаар тогтоолыг мөрдөж ажилласан байна. | Журмыг хэрэгжүүлсэн байна. | Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай ЭМДҮЗ-ийн 05 дугаар тогтоолыг гэрээ бүхий анхан шатны 13 эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. | 2024.01.02-2024.05.20 | 100 |
| 5 | **Арга хэмжээ 1.5** Даатгуулагчийг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд хамруулсан эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллана. | Санхүүжүүлсэн мөнгөн дүн -Хамрагдсан даатгуулагчийн тоо | - | Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж, гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-ын гүйцэтгэлд хяналт хийж, санхүүжилтийг баталгаажуулсан байна. | Энэ оны 1-9 дүгээр сард эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд 6288 даатгуулагчийг хамруулж 1,042,790,000 мянган төгрөгний зардлын төлбөр нэхэмжилсэнээс 5649 тохиолдлын 832,663,000 мянган төгрөгийн гүйцэтгэлийг олгохоор баталгаажуулж, 639 тохиолдлын 210,127,000 мянган төгрөгний зөрчлийг цахимын хяналтаар илрүүлэн хасч тооцсон байна. | 2024.01.02-2024.11.20 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | **Арга хэмжээ 1.6** ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас жил тутам дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал боловсруулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлнэ. | Хийсэн дүн шинжилгээний тоо, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн саналын тоо | | II улирлаар дүн шинжилгээ хийж, санал боловсруулан Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна. | ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас жил тутам дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний саналыг хагас жилээр боловсруулж, Бодлого төлөвлөлтийн газар хүргүүлэхээр төлөвлөөд байна. | 2024.01.02-2024.11.20 | 60 |
| **Зорилт 2. Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно:** | | | | | | | |
| 7 | **Арга хэмжээ 2.1** Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд санал өгнө. | Хүргүүлсэн саналын тоо | | Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд санал хүргүүлсэн байна | Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дүгээр тушаалаар баталсан бүртгэлийн болон тайлангийн шинэчилсэн хувилбартай танилцан төрөлтийн түүх, эмийн эмчилгээний эмийн хуудасны эмчилгээний хэсэгт 2, мөн анхан шатны эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээг хянах тогтоолын төслийн өрх, сум тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим тусламж үйлчилгээний шинэчлэн боловсруулсан "Өдрийн эмчилгээ"-ний шалгуурын төсөлд 12 санал тус тус хүргүүлсэн байна. | 2024.01.02-2024.11.20 | 80 |
| 8 | **Арга хэмжээ 2.2** Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, Прокурорын | -Зөрчлийн хэргийн тоо<br>-Санд төвлөрүүлсэн мөнгөн дүн | Лавлагаа мэдээлэлд хамрагдсан иргэдийн тоо 17, Санд төвлөрүүл | Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулсан байна. | Зөрчлийн хэргийн тоо- 184 Лавлагаа мэдээлэлд хамрагдсан иргэдийн тоо- 185 нийт нэхэмжилсэн хүний тоо 102 нэхэмжилсэн мөнгөн дүн-206,000,936 мянган төгрөг. Үүнээс санд төвлөрүүлсэн мөнгөн дүн 34,696,364.0 мянган төгрөг | 2024.01.02-2024.11.20 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ...хамтран ажиллана. | | ...дүн 158,0 мянган төгрөг */1 даатгуулагч/* | | Цагдаагийн газарт 51, прокурорын газар 133 удаа, Авлигатай тэмцэх газарт 1 удаа тус тус гарган өгсөн байна. | | |
| **Зорилт 3. Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусламж, үйлчилгээний тоо хэмжээг нэмэгдүүлнэ.** | | | | | | | |
| 9 | **Арга хэмжээ 3.1** Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. | Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь | 2023 оны хамрагдалтын хувь 22.0 | Малчдын эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг 30 хувь | 2024 онд нийт хамрагдвал зохих малчны тоо-3499, хамрагдсан-1729 хамрагдалтын хувь 49 байна. | 2024.01.02-2024.11.20 | 90 |
| | | Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь | 2023 оны хамрагдалтын хувь 28.3 | Оюутны эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг 40 хувь | 2024 онд нийт хамрагдвал зохих оюутны тоо-574, хамрагдсан-805 хамрагдалтын хувь 140 байна. | 2024.01.02-2024.11.20 | |
| | | Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь | 2023 оны хамрагдалтын хувь 100.3 | Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн хамрагдалтыг 100 хувь | 2024 онд хамрагдвал зохих тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэдийн тоо-2923, хамрагдсан-1962 хамрагдалтын хувь 67 байна. | 2024.01.02-2024.11.20 | |
| 10 | **Арга хэмжээ 3.2** Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж тайлан, мэдээг гарган холбогдох нэгжид хүргүүлнэ. | Нэгтгэн хүргүүлсэн тайлангийн тоо | - | Тайлан, мэдээг хугацаанд нь, үнэн зөв гарган хүргүүлсэн байна. | Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавин, ажиллаж байна. Гэрээт ЭМБ-ын 2018-2024 оны 1 дүгээр улирал хүртэлх хугацаанд олгосон санхүүжилтийн бүртгэл мэдээллийг тулган мөн төр хариуцахын ногдуулалтын мэдээлэл 1-5 сард нийт 5 удаа | 2024.01.02-2024.11.20 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ОБХ-т хүргүүлэв<br>Мөн гэрээт эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийн мэдээг 2024 оны 1-4 дүгээр сарын байдлаар гарган АЗДТГ, ЭМГ-т хүргүүлсэн<br>Гэрээт эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний зардлын бүртгэлийг сар бүр ЭМГ-т хүргүүлэн ажиллаж байна. | | |
| 11 | **Арга хэмжээ 3.3**<br>Эрүүл мэндийн даатгалын төсвийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт зардлын гүйцэтгэлийг хангуулж, тайлагнана. | Төлөвлөгөөний биелэлтийн хувь | 2023 онд биелэлт 96.6 хувь | ЭМД-ын орлогын төлөвлөгөөний биелэлт 97 хувь | 2024 оны 1-10 дугаар сарын өссөн дүнгээр нийт 10,874,438.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 10,752,124.0 мянган төгрөг төвлөрүүлэн орлогын төлөвлөгөөний биелэлт 98.8 хувьтай байна. Үүнээс ажил олгогч даатгуулагчийн шимтгэлийн орлого 10,073,000.0 мянган төгрөг буюу 99.7 хувь, шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн шимтгэлийн орлого 624,258.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 679,124.3 мянган төвлөрүүлж 108.7 хувийн биелэлттэй байна. | 2024.01.02-2024.11.20 | 100 |
| | **Зорилт 4. Даатгалын сангийн тогтвортой байдлыг хангаж, эрсдэлээс хамгаална.** | | | | | | |
| 12 | **Арга хэмжээ 4.1**<br>Өглөг, авлага үүсгэхгүй ажиллана. Авлага барагдуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авна. | Өглөг, авлагын тоо хэмжээ, тайлан | - | Өглөг, авлага барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч ажилласан байна | Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудаас тухайн сард үзүүлсэн тусламж үйлчилгээний зардлын гүйцэтгэлийн нэхэмжлэл, албан тоотыг dornod_invoice@nd.gov.mn хаягаар тогтсон хугацаанд хүлээн авч Outlook програмд архив | 2024.01.02-2024.11.20 | 84 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үүсгэн хадгалах, health.gov.mn болон санхүүгийн Fiscus програмын дүнтэй тулган хянаж байна. | | |
| **Зорилт 5. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн чанарт үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна.** | | | | | | | |
| 13 | **Арга хэмжээ 5.1** Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, эмийн сангуудын 2023 оны гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулна. | - Гэрээ дүгнүүлсэн байгууллагын тоо -Гэрээний хэрэгжилтийн хувь | Гэрээт 60 ЭМБ -Гэрээний хэрэгжилт 86.9 хувь | Гэрээний биелэлт 90 хувиас доошгүй. | 2023 онд ЭМДЕГ-тай гэрээ бүхий нийт 60 эрүүл мэндийн байгууллагуудын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг худалдан авах гэрээг дүгнэв. Үүнд: Лавлагаа шатлалын-5 Анхан шатны-16 Эмийн сан-39 байна. Гэрээг үнэлсэн байдлыг оноогоор авч үзвэл:<br>Лавлагаа шатлал-5 ЭМБ-с<br>88.92-оноогоор -1<br>99.07-99.59-оноогоор -4<br>Дундаж оноо 97.3 хувь<br>Анхан шатлалын 16 ЭМБ-с<br>76.38-79.14 оноогоор-6,<br>81.54-87.66 оноогоор-7<br>95.75-96.73 оноогоор-3<br>Дундаж оноо- 84.2<br>Эмийн сан-39<br>0-оноогоор-6<br>80-85 оноогоор-2<br>90-100 оноогоор- 31 гэрээний үнэлгээний дундаж оноо 79.8 байна. 0 оноогоор үнэлэгдсэн эмийн сангуудад зөрчлийг арилгуулах улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлж, | 2024.01.02-2024.11.20 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөрчлийг арилгах хүртэл цахим эрхийг түр түтгэлзүүлэх саналыг Худалдан авалт, гэрээлэлтийн газарт хүргүүлэн ажилласан. | | |
| **Зорилт 6. Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна** | | | | | | | |
| 14 | **Арга хэмжээ 6.1**<br>Олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурыг үндэслэн гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлнэ. | -Гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-ын тоо,<br><br>-Нэхэмжилсэн даатгуулагчийн тоо, мөнгөн дүн, | Анхан болон лавлагаа шатлалын 21 ЭМБ-аас 226,694 даатгуулагчийн 17,651,661.7 мянган төгрөгийн гүйцэтгэл хүлээн авсан Хянагдсан түврийн тоо-2600 Хасагдсан тохиолдлын тоо-1141, Мөнгөн дүн-136,391,200 мянган төгрөг | Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг журмын дагуу хэрэгжүүлсэн байна. | Лавлагаа шатлалын 5 эрүүл мэндийн байгууллагын 2024 оны 1-9 дүгээр сард үзүүлсэн тусламж үйлчилгээний гүйцэтгэл 209558 тохиолдлын 20,397,945.7 мянган төгрөг нэхэмжилсэнээс 207070 тохиолдлын 19,266,269.1 мянган төгрөгийг олгохоор тооцсон. лавлагаа шатлалын Мөн өөрт хуваарьлагдсан 18 ( *давхардсан тоогоор*) эрүүл мэндийн байгууллагын нийт 7010 түүвэр хуваарьлагдсан бөгөөд үүнд нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлэн шалгуурын дагуу үнэлэхэд 2115 тохиолдлын 232,7 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн хасч тооцсон байна.<br><br>Мөн гэрээ бүхий 16 (*анхан шатны*) эрүүл мэндийн байгууллагуудаас 2024 оны 1-10 дугаар сард нийт 77308 тохиолдлын 3,760,794.3 мянган төгрөгний гүйцэтгэл бүхий нэхэмжлэлийг хүлээн авч хяналтыг хэрэгжүүлэн 75792 тохиолдлын 3,610,150.5 мянган төгрөгний санхүүжилтийг олгохоор тооцож, (*шалгуур хангаагүй, анхан шатны* баримт | 2024.01.02-2024.11.20 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | *ирүүлээгүй, код ахиулсан давхардуулж нэхэмжилсэн, чанаргүй үзүүлсэн тусламж үйлчилгээ үзүүлсэн)* 1228 тохиолдлын 63,717,992.4 мянган төгрөгний зөрчлийг байцаагчийн хяналтаар илрүүлэн, баталгаажуулж ажилласан. Илэрсэн зөрчилд тайлбар жагсаалтыг давхардсан тоогоор нийт 19 эрүүл мэндийн байгууллагад 34 албан тоот төлөвлөн хавсралтаар хүргүүлсэн байна. | | |
| 15 | **Арга хэмжээ 6.2** Гэрээт эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ. | Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо | Гэрээ бүхий 19 эмийн сан | Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна. | Гэрээ бүхий 22 эмийн сангийн Новартис хөтөлбөрийн хүрээнд түгээгдэж байгаа эмийн хангалт, хадгалалт, хугацаа,мөн иргэдийг тус эмийн талаар мэдээ, мэдээллээр хэрхэн ханган ажилаж байгаа талаар болон Дашбалбар СЭМТ-ийн шүд, амны хөндийн тусламж үйлчилгээ үзүүлэх чадамжийг үнэлэх зөвлөн туслах зорилгоор газар дээрх хяналтыг хийж хэрэгжүүлсэн. | 2024.01.02-2024.11.20 | 100 |
| 16 | **Арга хэмжээ 6.3** Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд ЭМД-ын улсын байцаагч (ахлах)-ийн зөвлөмжийг тухай бүр хүргүүлж, биелэлтийг хангуулна. | Хүргүүлсэн зөвлөмжийн тоо<br>Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | - | Тусламж, үйлчилгээний чанар хэрхэн сайжирсан талаарх тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна. | Эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний нэхэмжлэлд нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлэн шаардлагатай тохиолдолд улсын байцаагчийн зөвлөмжийг хүргүүлэх эрх бүхий албан тушаалтны үнэмлэх, тэмдгийг 2024.03.18-ны өдөр хүлээн авч,хуулийн дагуу олгогдсон эрхийг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 2024.01.02-2024.11.20 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | **Арга хэмжээ 6.4**<br>Нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон даатгуулагчдын гомдол, санал д үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хяналт шалгалт хийнэ. | -Газар дээрх хяналт, шалгалт хийсэн ЭМБ-ын тоо<br>-Хяналт, шалгалтын тайлан | 2023 онд гэрээ бүхий 2 ЭМБ-д байгууллагад газар дээрх хяналт, шалгалтыг зохион байгуулсан. | Газар дээрх хяналт, шалгалт хийж тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна | - Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах лабораторийн тусламж үйлчилгээг үзүүлэх өрх, сум тосгоны эрүүл мэндийн төвийн чадамжийг үнэлэх,<br>- Швецарийн хөгжлийн агентлаг, Монгол улсын Засгийн газрын хамтарсан Новартис Аксес хөтөлбөрийн хүрээнд Новартис эмийн хүртээмжийг сайжруулах зорилгоор гэрээт эмийн сангуудад газар дээр нь очиж эмийн үлдэгдэл, хангалт, хугацаа зэрэгт хяналт шалгалт хийх,<br>- ЭМБ-с тусламж үйлчилгээ авсан талаар иргэдтйн бүртгэлтэй гар утсанд ирүүлсэн мессеж үйллчилгээний гомдолд үндэслэн ЭМБ-д хяналт хийх,<br>- СЭМТ-ийн шүд амны хөндийн тусламж үйлчилгээ үзүүлэх чадамжийг үнэлэх, зөвлөн туслах ажлыг газар дээр нь зохион байгуулж тайлан мэдээг холбогдох газарт хүргүүлэн ажилласан. | 2024.01.02-2024.11.20 | 100 |
| **Зорилт 7. Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинө.** | | | | | | | |
| 18 | **Арга хэмжээ 7.1**<br>Ерөнхий газраас баталсан Сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтад тогтмол хамрагдана. | -Хамрагдсан сургалтын тоо | ЭМДЕГ-аас зохион байгуулсан сургалтад тогтмол хамрагдсан. | Ерөнхий газраас зохион байгуулах нийт сургалтад тогтмол хамрагдаж мэдээлэл авсан байна. | Энэ онд ЭМДЕГ-с зохион байгуулсан ЭМДҮЗ-ийн 2024 оны 06,08 дугаар тогтоолын шинэчилсэн төслийг танилцуулах цахим сургалтад 6 удаа , ЭМДЕГ-ын Тамгын газрын "Мэдээллийн цаг" хөтөлбөр 23 удаа, Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалт | 2024.01.02-2024.11.20 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 21 удаа хамрагдсан. | |
| 19 | **Арга хэмжээ 7.2** Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, даатгалын орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нээлттэй өдөрлөг, сургалт, сурталчилгааны бусад арга хэмжээг зохион байгуулна. | Зохион байгуулсан арга хэмжээ, сургалтын тоо | Зохион байгуулсан арга хэмжээ-27 | Сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, тайлагнасан байна. | Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг тайлбарлан таниулах зорилгоор гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудад цахимаар-4, танхимаар-4 удаа сургалт зохион байгуулав. Үүнд: анхан шатны 16 байгууллагын 40, лавлагаа шатлалын 2 эрүүл мэндийн байгууллагын нийт 136 эмч, мэргэжилтнүүд хамрагдсан байна.Түүнчлэн их дээд сургууль, МСҮТ, Полтехникийн коллежийн оюутан суралцагчдад танхимаар 2 удаа сургалт мэдээлэл зохион байгуулав. Хамрагдсан оюутны тоо 110 Мөн төрийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчлан таниулах, тэдэнд ойртсон төрийн үйлчилгээг хүргэх зорилгоор Нийгмийн даатгалын газартай хамтран томоохон зах худалдааны төвүүдэд "Нээлттэй хаалга"-ны өдөрлөг зохион байгуулав. Өдөрлөгийн үеэр 196 иргэн даатгуулагчид зөвлөгөө мэдээлэл хүргэсэн бөгөөд 6 иргэний ЭМД-ын шимтгэлийн E-Barimt аппликейшн ашиглан төлүүлсэн байна. | 2024.01.02-2024.11.20 |
| 20 | **Арга хэмжээ 7.3** Байгууллагын үйл ажиллагаа болон мэдээллийн ил тод байдлыг хангуулах ажлыг | Иргэд, даатгуулагчдад хүргэсэн мэдээлэл, хандалтын тоо | 391 мэдээлэл 31182 мянган хүнд | 32000-с доошгүй Иргэн даатгуулагчдад мэдээлэл хүргэсэн байна. | Иргэд, даатгуулагчдад эрүүл мэндийн даатгалын талаарх мэдээ мэдээллийг хэлтсийн фэйсбүүк хуудас болон нээлттэй утсаар тасралтгүй хүргэсээр | 2024.01.02-2024.11.20 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, иргэн-даатгуулагчидад бодит мэдээ, мэдээлэл хүргэнэ. | | хүрсэн | | байна.<br>Хэлтсийн фэйсбүүк хуудсыг хөгжүүлэхэд анхаарч тайлант хугацаанд:<br>-Мэндчилгээ,<br>-Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиас,<br>-Санхүүжилтийн мэдээ, -Шимтгэл төлөлтийн хувь хэмжээ,<br>-Шимтгэл төлөх заавар зэргийг байршуулан ажилласан.<br>ЭМДЕГ-ын цахим хуудсанд байршсан мэдээ мэдээлэл, контентыг түгээн ажиллаж байна. | | |
| 21 | **Арга хэмжээ 7.4**<br>Даатгуулагч-иргэд, гэрээт байгууллага, ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, түүний мөрөөр зохих арга хэмжээг авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлнэ. | Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо | 2023 онд 248 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. | Сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна. | Гэрээ бүхий хувийн хэвшлийн 3 эрүүл мэндийн байгууллагуудад амбулатороор үзүүлсэн 72, хэвтэн эмчлүүлсэн 148 иргэнээс сэтгэл ханамжийн судалгааг авав. Сэтгэл ханамжийн судалгаанаас дүгнэхэд эрүүл мэндийн даатгалаа төлсөнөөр иргэдийн халааснаас гарах мөнгө багассан, эмнэлгээс үзүүлэх тусламж үйлчилгээ сайжирч, хүлээгдэл, очер дугааргүй болсон талаар судалгаанд хамрагдагсдын 91 хувь дурьдсан байна.<br>Мөн эрүүл мэндийн даатгалаа цахимаар төлж, шалгадаг нь цаг хэмнэсэн хялбар болсон талаар нийт судалгаанд хамрагдсан иргэний 67 хувь нь сэтгэл ханамж өндөр байгаагаа илэрхийлсэн байна.<br>Эмнэлэг хэвтэх хугацаанд эм тариа авахуулсан эсэх талаар гомдол санал гаргаагүй. Мөн | 2024.01.02-2024.11.20 | 80 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 22 | **Арга хэмжээ 7.5** Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд, үнэн зөв шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлагнана. | Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь | Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо 262, шийдвэрлэлт 100 хувь. | Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хагас, бүтэн жилээр нэгтгэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна | Тайлант хугацаанд тус хэлтэст бүртгэж хүлээн авсан албан бичиг-78, төлөвлөж хүргүүлсэн-128.байна. Үүнээс<br>Хүлээж авсан дотоод бичиг- 35,<br>Хүргүүлсэн дотоод бичиг- 10<br>Хариутай албан бичиг 57 байна<br>Мөн иргэдээс ирсэн гомдол, санал хүсэлт -250 тус тус бүртгэгдсэн байна.<br>Санал хүсэлт, өргөдөл гомдлыг хандсан хэлбэрээр нь ангилвал<br>Цахимаар-68<br>Лавлах утсанд хандсан-107<br>Биечлэн ирсэн-75<br>Өргөдөл гомдол, санал хүсэлтийг агуулгаар нь ангилвал:<br>- шимтгэл төлөлттэй холбоотой асуудлаар-147<br>- Тусламж үйлчилгээтэй холбоотой асуудлаар-2<br>- Төрсөн эхийн төр хариуцах бүртгэл ногдуулалт-10<br>- Шинээр төрсөн хүүхдийн бүртгэл үүсгэх-23<br>Бусад-68 хандсан байна.<br>Хугацаа хоцорч шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл гомдол байхгүй болно.<br>Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг 1,2,3 дугаар улирлаар нэгтгэн хүргүүлсэн. | 2024.01.02-2024.11.20 |
| 23 | **Арга хэмжээ 7.6** Албан хэрэг хөтлөлтийн | Бүрдүүлсэн архивын нэгжийн | 2023 онд 21 | Албан хэрэг хөтлөлтийн үйл | Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг өдөр тутмын үйл | 2024.01.02-2024.11.20 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлж, ЭМДЕГ-ын архивт хугацаанд хүлээлгэж өгнө. | Тоо | архивын нэгж бүрдүүлсэн. | ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлсэн байна. | ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж, ЭМДЕГ-ын даргын Хөтлөх 21 хэргийн нэрийн жагсаалтын дагуу хадгаламжийн нэгж бүрдүүлэн ажиллаж байна. 2023 оны 38 боть архивын нэгж үүсгэн, 2024 оны эхний хагас жилийн 8 архивын нэгж баримтыг эмхлэн цэгцэлж үдэхэд бэлэн болгоод байна. | | |
| 24 | **Арга хэмжээ 7.7** Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаан, цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөв тайлагнана. | Хугацаанд нь тайлагнасан үүрэг даалгаврын тоо, хэрэгжилтийн хувь. | Үүрэг даалгаврын тоо 28 хэрэгжилтийн хувь 100% | Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөв тайлагнасан байна. | Энэ оны эхний 1-10 сарын байдлаар долоо хоног бүрийн Даваа гарагт зохион байгуулагддаг удирдлагын шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн тайлан, мэдээг нийт 15 удаа хүргүүлж ажиллалаа. | 2024.01.02-2024.11.20 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 25 | Агентлаг болон бусад байгууллага, төсөл хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдах сургалт, семинарт бүрэн хамрагдана | Зохион байгуулагдсан сургалтад бүрэн хамрагдсан байна. | ТАЗ-н пүрэв гарагийн 21 удаагийн, мэдээллийн цагийн 12 удаагийн сургалт, монгол бичгийн 22 удаагийн хичээлд тус | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2024 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан болон хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр | Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт хамтын хорооны үйл ажиллагааг сурталчлан таниулах, нийгмийн түншлэлийг анхан дунд шатанд хөгжүүлэх Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийн хэрэгжилтийг хангуулах сарын аяны хүрээнд "Нийгмийн түншлэл ба Хөдөлмөрлөх эрх" сэдэвт | 2023.01.02-2023.11.20 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тус хамрагдсан. | зохион байгуулагдсан сургалтад хамрагдана.. | сургалт зөвлөгөөнд оролцсон, Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалт 21 удаа, Төрийн албан зөвлөлөөс тус аймгийн нийт төрийн албан хаагчдад зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль" түүнийг дагаж гарсан дүрэм журмын талаар сургалт, Дорнод аймгийн төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн, Прокурорын байгууллагаас зохион байгуулсан ЭБАТ-д ЗШША-г хэрхэн зохион байгуулах талаар нэгдсэн зөвлөгөөнд тус тус хамрагдав. | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн ........................................ /Ш.ЭНХМАА/

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*